

**МОНГОЛ УЛС, АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК ХООРОНДЫН "АЙМАГ, СУМЫН БҮСЧИЛСЭН НОГООН ХӨГЖЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР"-ИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ТӨСЛИЙН ЗӨВШИЛЦӨХ ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодтой зөвшилцөхөөр ирүүлсэн билээ.

Төсвийн байнгын хороо 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаараа дээрх төслийн зөвшилцөх асуудлыг хэлэлцлээ.

Төслийн хүрээнд хөдөө аж ахуйн бизнесийн хөрөнгө оруулалтыг хэрэгцээт газар нь хүргэхэд учирч буй саад бэрхшээлийг багасгах, улсын хэмжээнд эдийн засаг, уул уурхайгаас хэт хамааралтай байдлыг бууруулах, эдийн засгийн төрөлжилтийг дэмжихэд шаардлагатай хүчин зүйлс буюу орон нутгийн хөгжил, ажлын байр нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлнэ гэж төлөвлөсөн байна.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хэлэлцүүлгийн явцад бүх аймгууд болон алслагдсан гурван дүүргийг хамруулах нь зүйтэй, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар зээлийн хэлэлцээрийн хэрэгжилт, зарцуулалтад онцгой анхаарч мэргэжлийн байгууллагуудын оролцоог хангаж ажиллах нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.


Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг Төсвийн байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх зөвшилцөхийг дэмжиж, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс, Азийн хөгжлийн банк хоорондын "Аймаг, сумын бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр"-ийн Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн төслийг зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Ж.БАТЖАРГАЛ**